

**НЭГ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ**

**1.1 Шинэ хэрэглэгч болох**

- 1.1.1 Шинэ хэрэглэгч Хавсралт 1.1-д заасан нэг удаагийн суурилуулалтын хураамжийн төлбөрийг төлнө.
- 1.1.2 Хэрэглэгч нэмэлтээр WiFi төхөөрөмжийг худалдан авч ашиглах тохиолдолд Хавсралт 1.1-д заасан төхөөрөмжийн төлбөрийг төлнө.
- 1.1.3 Суурилуулалтын хураамж болон WiFi төхөөрөмжийн төлбөрийг эхний сарын төлбөр дээр нэхэмжилнэ.
- 1.1.4 Шинэ хэрэглэгч Өрхийн Интернэтийн үйлчилгээг 12 сараар гэрээ байгуулан авах тохиолдолд суурилуулалтын хураамжаас чөлөөлнө.

**1.2 Үйлчилгээний хугацаа**

- 1.2.1 Өрхийн Интернэтийн үйлчилгээ нь хугацаагүй эсхүл 12 сарын хугацаатай гэсэн 2 төрөл байна.
- 1.2.2 Өрхийн Интернэтийн үйлчилгээ нь хэрэглэгч үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч, талууд гарын үсэг зурж баталгаажуулан хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн үндсэн гэрээ болон энэхүү үйлчилгээний нөхцөлд заасны дагуу үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар болон хэрэглэгчийн хүсэлтээр үйлчилгээ цуцлагдах хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.2.3 12 сарын хугацаатай үйлчилгээ авсан хэрэглэгчийн үйлчилгээний хугацаа дуусгавар болсон тохиолдолд талууд үйлчилгээний нөхцөлд өөрчлөлт оруулах санал гаргаагүй бол үйлчилгээг ижил нөхцөл, хугацаагаар сунгагдсанд тооцно.

**1.3 Өрхийн Интернэтийн багц**

- 1.3.1 Хэрэглэгч Хавсралт 1.2-т заасан хэрэглээний хязгааргүй болон хурдны хязгааргүй багцуудаас сонгон ашиглах боломжтой.
- 1.3.2 Багцын сарын хураамж нь доорх нөхцөлүүдээс бусад тохиолдолд Өрхийн Интернэт үйлчилгээг ашигласан эсэхээс үл хамааран сар бүр нэхэмжлэгдэнэ. Үүнд:
  - 1.3.2.1 Хэрэглэгч Өрхийн Интернэт үйлчилгээг хадгалуулсан; 1.3.2.2 Хууль болон гэрээнд заасны дагуу үйлчилгээ үзүүлэгчийн санаачлагаар хэрэглэгчийн үйлчилгээг бүхэлд нь зогсоосон.
- 1.3.3 Шинэ хэрэглэгч сарын дундуур үйлчилгээ авсан тохиолдолд багцын сарын хураамжийг тухайн сарын үлдэгдэл хоногт дүйцүүлэн нэхэмжилнэ.
- 1.3.4 Хэрэглэгч 12 сарын хугацаатай үйлчилгээ авсан тохиолдолд тухайн хугацаандаа Хавсралт 1.2-т заасан багцын сарын хураамжийн хөнгөлөлт эдэлнэ.
- 1.3.5 Төлбөр төлөөгүйн улмаас үйлчилгээний эрхээ хаалгасан хэрэглэгчийн тухайн сарын хураамжийг бүтэн нэхэмжилнэ.
- 1.3.6 Хурдны хязгааргүй багц нь:
  - 1.3.6.1 Хэрэглэгчийн сонгосон тухайн багцад харгалзах дата хэрэглээний эрхэд хурдны хязгааргүй, багцад харгалзах дата эрхээс хэтэрсэн тохиолдолд Хавсралт 1.2-т заасан хурдны хязгаарлалттай байна.
  - 1.3.6.2 Хэрэглэгч нь хэрэглэгчийн булан болон өөрийн бүртгүүлсэн дугаараасаа 132222 тусгай дугаарт "Username B" гэж мессэж илгээн өдөрт 1 удаа дата хэрэглээний мэдээллийг шалгах боломжтой.
  - 1.3.6.3 Тухайн багцад харгалзах дата эрх дууссан тохиолдолд Хавсралт 1.4-т заасан нэмэлт дата багц бүртгэлтэй утасны дугаараасаа мессэж бичин идэвхжүүлж хурдаа буцаан нэмэгдүүлэх боломжтой бөгөөд нэмэлт дата эрхийн төлбөр нь өрхийн интернэт үйлчилгээний нэхэмжлэх дээр нэмэгдэж тооцогдоно.
  - 1.3.6.4 Тухайн сардаа ашиглаж дуусаагүй дата хэрэглээний үлдэгдэл эрх нь дараа сардаа шилжихгүй.
  - 1.3.6.5 Хурдны хязгааргүй багцыг зөвхөн GPON (Gigabit Passive Optic Network) холболттой үед ашиглах боломжтой бөгөөд хэрэглэгч PPTP (Point to Point Tunneling Protocol) үйлчилгээ болон MobiNet Easy, MobiNet Booster нэмэлт үйлчилгээг ашиглах боломжгүй байна.

**ХОЁР. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 2.1 Хэрэглэгч нь гэрээ байгуулахаас өмнө сүлжээнд холбогдоход шаардлагатай компьютер, программ хангамжийг бүрдүүлж бэлэн болгосон байна. Хэрэглэгчийн компьютер, дотоод сүлжээний гэмтэл, программ хангамж зэрэгт гарсан үйлчилгээ үзүүлэгчээс үл шалтгаалах гэмтлийг үйлчилгээ үзүүлэгч хариуцахгүй.
- 2.2 Хэрэглэгч Өрхийн Интернэтийн дараа төлбөрт үйлчилгээг зөвхөн өрхийн хэрэглээний зориулалтаар ашиглана.
- 2.3 Хэрэглэгч сүлжээнд хандах нэр, нууц үгээ хадгалах, сүлжээгээр дамжуулж буй мэдээллээ нууцлах, компьютерын вирус, бусдын халдлагаас хамгаалах үүрэгтэй.

- 2.4 Хэрэглэгч үйлчилгээг гэрээнд дурьдсанаас өөр хаягтай хэрэглэгчид салаалах болон дамжуулан борлуулахыг хатуу хориглоно.
- 2.5 Хэрэглэгч аливаа үйлчилгээ авахад зөвхөн өөрийн биеэр цахим үнэмлэхтэйгээ үйлчилгээний салбарт ирнэ. Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийг өөрийн биеэр ирэх боломжгүй бол нотариатаар баталгаажуулсан итгэмжлэлийг үндэслэн зөвхөн итгэмжлэлд заасан үйлчилгээг итгэмжлэгдсэн төлөөлөгчид үзүүлнэ.
- 2.6 Хэрэглэгч нь насанд хүрэгчдэд зориулсан контент (+18) руу хандах интернэтийн зохистой хэрэглээг удирдахын тулд customer.mobinet.mn хуудасны "Эцэг эхийн хяналт" гэсэн цонхыг идэвхжүүлэх боломжтой.
- 2.7 Хурдны хязгааргүй багц ашиглаж буй хэрэглэгч "Эцэг эхийн хяналт" үйлчилгээг зөвхөн сарын эхний өдөр идэвхжүүлэх болон цуцлах боломжтой байна.
- 2.8 12 сарын хугацаатай гэрээ байгуулсан хэрэглэгчийн үйлчилгээ ашиглах байршил өөрчлөгдөх буюу хэрэглэгч нүүсэн тохиолдолд шинэ байршилд Мобинетийн сүлжээ ороогүй шалтгаанаар хэрэглэгч үйлчилгээг ашиглахгүй байх эсвэл үйлчилгээг цуцлах нь хугацаатай гэрээний нөхөн төлбөрөөс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

**ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ**

- 3.1 Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчид Өрхийн Интернэтийн үйлчилгээг хэрэглэгчийн сонгосон хурдаар хүргэнэ.
- 3.2 Үйлчилгээ үзүүлэгч нь аливаа техникийн гэмтэл, гэнэтийн саатал гарсан тохиолдолд хурдан шуурхай засварлах үүрэгтэй.
- 3.3 Үйлчилгээ үзүүлэгч нь аливаа техникийн гэмтэл, гэнэтийн саатал гарсан тохиолдолд хурдан шуурхай засварлах үүрэгтэй.
- 3.4 Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний төлбөр төлөгдсөн даруйд хэрэглэгчийн үйлчилгээний эрхийг нээх үүрэгтэй.
- 3.5 Үйлчилгээ үзүүлэгч нь насанд хүрэгчдэд зориулсан +18/ үйлчилгээг үзүүлэх бөгөөд уг үйлчилгээг хурдны хязгааргүй багцын хэрэглэгчдийн хувьд зөвхөн сарын эхний өдөр, харин хэрэглээний хязгааргүй багцын хэрэглэгчдийн хувьд хүсэлт гаргасан даруйд идэвхжүүлэх болон хязгаарлах боломжтой.

**ДӨРӨВ. ТӨЛБӨР ТООЦОО**

**4.1 Төлбөрийн нэхэмжлэх**

- 4.1.1 Үйлчилгээ үзүүлэгч үйлчилгээний төлбөрийг сар бүрийн 01-с 31-ний өдрөөр тасалбар болгон дараа сарын 07-ны дотор хэрэглэгчээс нэхэмжилнэ.
  - 4.1.2 Төлбөрийн нэхэмжлэл нь тухайн сарын багцын хураамж, нэмэлт үйлчилгээний дүнгээс зохих хөнгөлөлтийг хасч тооцсоны дараах дүн, өмнөх сарын төлбөрийн үлдэгдэл, НӨАТ зэргээс бүрдэнэ.
  - 4.1.3 Хэрэглэгч нь 4.1.1-д заасан төлбөрийг нэхэмжилсэн сарын 20-ны дотор үлдэгдэлгүй, бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.
  - 4.1.4 Хэрэглэгч нь үйлчилгээний төлбөрийг үйлчилгээ үзүүлэгчийн заасан дансанд, үйлчилгээний салбарт бэлнээр, мобайл банк, www.mobicom.mn, MobiXpress болон бусад боломжит сувгаар төлнө.
  - 4.1.5 Хэрэглэгч 4.1.3-т заасан хугацаанд төлбөрийн үлдэгдлээ бүрэн барагдуулаагүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч нь төлбөр бүрэн төлөгдөх хүртэл хэрэглэгчийн Өрхийн Интернэт үйлчилгээг түр хаана.
  - 4.1.6 Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн үйлчилгээг төлбөр төлөөгүйн улмаас түр хаагдсанаас хойш 14 хоногийн хугацаанд www.mobicom.mn болон Хаан банк, Голomt банк, Худалдаа хөгжлийн банк, Төрийн банкны онлайн худалдаа хийх, төлбөр төлөх боломжтой вэб сайтуудыг нээлттэй байлгах бөгөөд бусад хандалтыг бүрэн хаана.
  - 4.1.7 Өрхийн Интернэт үйлчилгээг 12 сараар авсан хэрэглэгч 2 сараас их хугацаанд төлбөрийн үлдэгдлээ барагдуулаагүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчээс 6.1.3-т заасан төлбөрийг нэхэмжилнэ.
  - 4.1.8 Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн тавьсан саналын дагуу дуудлагаар очин үйлчилгээ үзүүлэх боломжтой ба үйлчилгээ үзүүлэгчээс шалтгаалаагүй гэмтлийг Хавсралт 1.3-т заасан дуудлагаар очиж үзүүлэх үйлчилгээний үнэ тарифт заасны дагуу төлбөртэй үзүүлнэ.
- 4.2 Төлбөрөө хугацаандаа төлсний хөнгөлөлт**
- 4.2.1 Төлбөрөө хугацаандаа төлсний хөнгөлөлт нь тухайн гэрээнд үйлчлэх хөнгөлөлт бөгөөд хэрэглэгч нэхэмжилсэн төлбөрийг тухайн сарын 20-ны дотор бүрэн төлсөн тохиолдолд дараа сарын төлбөрийн НӨАТ тооцоогүй дүнгээс 5%-ийн хөнгөлөлтийг хасч тооцно.
  - 4.2.2 Хугацаандаа төлсний хөнгөлөлтөд WiFi төхөөрөмжийн төлбөр болон захиалгат үйлчилгээний төлбөрүүд хамаарахгүй.

**4.3 Гэмтэл саатлын хөнгөлөлт**

- 4.3.1 Үйлчилгээ үзүүлэгчээс шалтгаалан хэрэглэгчийн үйлчилгээ 24 цагаас дээш хугацаагаар тасалдсан тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч нь хоног тутамд хэрэглэгчийн ашиглаж буй багцын сарын хураамжийн 2%-иар тооцон хөнгөлөлт олгоно.
- 4.3.2 Үйлчилгээ үзүүлэгчээс шалтгаалан Өрхийн Интернэтийн үйлчилгээ 24 цагаас бага хугацаагаар тасалдсан тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч нь хөнгөлөлт тооцон олгохгүй.
- 4.3.3 Хэрэглэгчийн үйлчилгээ тухайн сард 24 цагаас бага хугацаагаар 1 ба түүнээс олон удаа тасалдсан тохиолдолд тухайн сарын тасалдлуудыг нэмэгдүүлж тооцон хөнгөлөлт олгохгүй.
- 4.3.4 24 цагаас их хугацаагаар тасалдсан гэмтэл саатлын хөнгөлөлт тооцоходоо бүрэн бус цагаар буюу тухайн минутанд ноогдох хувиар тооцон хөнгөлөлт олгоно.
- 4.3.5 Гэмтэл саатлаас шалтгаалсан хөнгөлөлтийн дээд хэмжээ нь багцын сарын хураамжийн нийт дүнгийн 50%-иас хэтрэхгүй байна.

**ТАВ. ЗАХИАЛГАТ ҮЙЛЧИЛГЭЭ**

**5.1 Багц солих**

- 5.1.1 Багц солих гэдэг нь Интернэтийн хурд болон багцын сарын хураамжаа өөрчлөхийг хэлнэ.
- 5.1.2 Багц солих үйлчилгээг сарын 01-ний өдөр үзүүлэх ба хэрэглэгч сарын дундуур багц солих хүсэлт гаргасан тохиолдолд ажилтан хэрэглэгчийн хүсэлтийг бүртгэн авах бөгөөд дараа сарын 01-ний өдөр багц автоматаар солигдоно.
- 5.1.3 Багц солих үйлчилгээг сард нэг удаа авах боломжтой байна.
- 5.1.4 Шинэ багцын сарын хураамжийг дараа сарын 01-нээс эхлэн тооцно.

**5.2 Гэрээ шилжүүлэх**

- 5.2.1 Гэрээ шилжүүлэх гэдэг нь Өрхийн Интернэт үйлчилгээг эзэмших эрхээ өөр хэрэглэгчид шилжүүлэхийг хэлнэ.
- 5.2.2 Гэрээ шилжүүлэх үйлчилгээг хэрэглэгчийн төлбөрийн нэхэмжлэх бодогдсоноос хойш тухайн сарын сүүлийн өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэх боломжтой.
- 5.2.3 Гэрээ шилжүүлэх үйлчилгээг хамгийн багадаа 1 сар ашигласан хэрэглэгч авна.
- 5.2.4 Гэрээ шилжүүлэх хэрэглэгч төлбөр тооцооны үлдэгдэлгүй байх шаардлагатай бөгөөд багцын сарын хураамжийг гэрээ шилжүүлэх хүсэлт гаргасан өдрийг хүртэлх ашигласан хоногт дүйцүүлэн тооцно.
- 5.2.5 Шинэ хэрэглэгчийн хувьд багцын сарын хураамжийг гэрээ шилжүүлэн авсан өдрөөс эхлэн сарын үлдсэн хоногт дүйцүүлэн тооцно.
- 5.2.6 Өрхийн Интернэт үйлчилгээний эзэмшигч өөрчлөгдөхгүйгээр хэрэглэгчийн үйлчилгээ ашиглах байршил өөрчлөгдөж байгаа тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч хэрэглэгчийн мэдээллийг шинэчлэн Хавсралт 1.3-т заасан тарифын дагуу сүлжээг ахин холбоно.

**5.3 Урьдчилсан төлбөрт үйлчилгээний хэрэглэгч дараа төлбөрт нөхцөл рүү шилжих**

- 5.3.1 Хэрэглэгчийн Өрхийн Интернэт үйлчилгээний дараа төлбөрт нөхцөл рүү шилжих хүсэлтийг хүсэлт гаргасан тухайн өдөрт биелүүлнэ.
- 5.3.2 Урт хугацаагаар сунгалт хийлгэсэн урьдчилсан төлбөрт хэрэглэгчийн үйлчилгээг дараа төлбөрт нөхцөл рүү шилжүүлэхдээ урьдчилан төлсөн төлбөрийг тооцоолон илүү төлөлтөөр оруулна.

**5.4 Урьдчилсан төлбөрт нөхцөлөөс дараа төлбөрт нөхцөл рүү шилжсэн хэрэглэгч ахин урьдчилсан төлбөрт нөхцөл рүү шилжих:**

- 5.4.1 Урьдчилсан төлбөрт үйлчилгээнээс дараа төлбөрт нөхцөл рүү шилжсэн хэрэглэгч буцаад урьдчилсан төлбөрт үйлчилгээ рүү шилжихэд үйлчилгээг хамгийн багадаа 1 сар ашигласан байх шаардлагатай бөгөөд 6.1-д заасан хэрэглэгчийн хүсэлтээр үйлчилгээ цуцалж буйд тооцон төлбөр тооцоог барагдуулна.

**5.5 Өрхийн Интернэт үйлчилгээ хадгалах**

- 5.5.1 Хэрэглэгч Өрхийн Интернэт үйлчилгээг хадгалуулах хугацаагаар урьдчилан сонгож Хавсралт 1.1-т заасан хадгалах үйлчилгээний төлбөрийг урьдчилан төлнө.
- 5.5.2 Өрхийн Интернэт үйлчилгээг 12 сарын хугацаатай нөхцөлөөр авсан хэрэглэгч тухайн хугацаанд хадгалах үйлчилгээг авах боломжгүй байна.
- 5.5.3 Үйлчилгээ хадгалах хугацааг хуанлийн бүтэн сараар тооцох бөгөөд нэг удаад 12 сараас ихгүй хугацаагаар хадгалуулах боломжтой байна.
- 5.5.4 12 сар хадгалсан үйлчилгээг 1 сар ашигласны дараа дахин хадгалуулах эрх үүснэ.
- 5.5.5 Хэрэглэгчийн Өрхийн Интернэт үйлчилгээг хадгалах хүсэлтийг хүсэлт гаргасан тухайн өдөрт нь гүйцэтгэж, үйлчилгээний эрхийг

- бүрэн хаана.
- 5.5.6 Хэрэглэгч сарын 1-нээс хойш хадгалуулах үйлчилгээ авсан бол тухайн сарыг хадгалах хугацаанд оруулж тооцохгүй бөгөөд багцын сарын хураамжийг бүтэн нэхэмжилнэ.
- 5.5.7 Хэрэглэгч үйлчилгээг хадгалуулахад төлбөрийн үлдэгдэлгүй байх шаардлагатай.
- 5.5.8 Хэрэв тухайн сарын төлбөр бодогдож гараагүй байх /сар бүрийн 1-7ны хооронд/ тохиолдолд дараа сард хэрэглэгчээс тухайн сарын төлбөрийг нэхэмжлэх бөгөөд хэрэглэгч төлбөр нэхэмжлэгдсэн сарын 20-ны дотор төлбөрөө бүрэн барагдуулах үүрэгтэй.
- 5.5.9 Шинэ хэрэглэгч нь хамгийн багадаа 3 сар үйлчилгээг ашиглаж байх хадгалуулах эрхтэй болно.
- 5.5.10 Хэрэглэгчийн хүсэлт гаргасан хадгалах хугацаа дуусахад дараа сарын 1-нд үйлчилгээний эрх автоматаар нээгдэж тухайн сарын багцын хураамжийг бүтэн нэхэмжилнэ.

**5.6 Өрхийн Интернэт үйлчилгээг нээх**

- 5.6.1 Хэрэглэгчийн хүсэлт гаргасан тухайн өдөр Өрхийн Интернэт үйлчилгээг нээж өгнө.
- 5.6.2 Сарын дундуур үйлчилгээ нээлгэж байгаа тохиолдолд багцын сарын хураамжийг сарын үлдсэн өдөрт дүйцүүлэн нэхэмжилнэ.
- 5.6.3 Хэрэглэгч үйлчилгээг нээлгэх үед төлбөрийн үлдэгдэлтэй бол төлбөрөө бүрэн барагдуулах үүрэгтэй.
- 5.6.4 Төлбөрөөс хаалттай үйлчилгээг нээлгэж байгаа тохиолдолд тухайн сарын багцын хураамжийг бүтэн нэхэмжилнэ.
- 5.6.5 Хэрэглэгч хадгалуулсан үйлчилгээг нээлгэх хүсэлтээ дараах хэлбэрээр гаргах боломжтой. Үүнд:  
5.6.5.1 Үйлчилгээний салбарт;  
5.6.5.2 2222 лавлах шугамд (Бусад сүлжээнээс 1800-2222 дугаарт).

**ЗУРГАА. ҮЙЛЧИЛГЭЭ ЦУЦЛАХ**

**6.1 Хэрэглэгчийн хүсэлтээр үйлчилгээ цуцлах**

- 6.1.1 Хэрэглэгчийн үйлчилгээ цуцлах хүсэлтийг тухайн сарын төлбөрийн нэхэмжлэх бодогдсон хугацаанаас хойш хүсэлт гаргасан өдөрт нь гүйцэтгэж, багцын сарын хураамжийг үйлчилгээ цуцлах өдрийг хүртэлх ашигласан хоногт дүйцүүлэн тооцно.
- 6.1.2 Багцын сарын хураамжийг тооцоход тухайн сар хэд хоногтойгоос хамааруулан тооцно.
- 6.1.3 12 сарын хугацаатай үйлчилгээ авсан хэрэглэгч үйлчилгээ цуцлах тохиолдолд Хавсралт 1.1-д заасан WiFi төхөөрөмжийн төлбөр болон Хавсралт 1.2-т заасан хөнгөлөлттэй үнээр нэхэмжилсэн саруудын багцын сарын хураамжийн зөрүү төлбөрийг төлж барагдуулна.
- 6.1.4 Хэрэглэгч нь үйлчилгээ цуцлах өдрийг хүртэлх хугацаанд ашигласан үйлчилгээний төлбөрийг бүрэн барагдуулах үүрэгтэй.

**6.2 Үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс үйлчилгээ цуцлах**

- 6.2.1 Үйлчилгээ үзүүлэгч дараах тохиолдолд үйлчилгээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:  
6.2.1.1 Сүлжээнд холбох боломжгүй тохиолдолд;  
6.2.1.2 Төлбөрөө төлөөгүй хэрэглэгчийн үйлчилгээг 3 сар хадгалан 4 дэх сард;  
6.2.1.3 Өрхийн Интернэт үйлчилгээг хадгалуулсан хэрэглэгч 5.5.8-д заасан хугацаанд төлбөрийн үлдэгдлээ барагдуулаагүй бол үйлчилгээ автоматаар нээгдэх сард;  
6.2.1.4 Хэрэглэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн бол;  
6.2.1.5 Хэрэглэгч өргөдлийн маягтын мэдээллийг худал мэдүүлсэн бол;  
6.2.1.6 Үйлчилгээ үзүүлэгчийн бусад үйлчилгээнд төлбөрийн маргаантай бол;  
6.2.1.7 Захиалга өгсөнөөс хойш 21 хоногийн хугацаанд хэрэглэгчтэй холбогдож холболт хийгээгүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч нь гэрээ байгуулсан эсэхээс үл хамааран холболтын захиалгыг цуцлах эрхтэй.

**ДОЛОО. ХАРИУЦЛАГА**

- 7.1 Үйлчилгээ үзүүлэгч дараах тохиолдолд хариуцлага хүлээхгүй.  
7.1.1 Гэнэтийн буюу давтагдашгүй хүчин зүйлийн шинжтэй, онцгой нөхцөл байдлын улмаас хохирол учирвал;  
7.1.2 Хэрэглэгчийн өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас гэмтэл гарсан үед.
- 7.2 Хэрэглэгч нь энэхүү гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлж буй үйлчилгээний эрхийг ашиглан МУ-ын Эрүүгийн хуульд заасан компьютер, мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг болон түүнтэй адилтгах хууль бус үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 7.3 Хэрэглэгч гэрээний 7.2-т заалтыг зөрчсөний улмаас эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг үйлчилгээ үзүүлэгч биелүүлсэнтэй холбогдуулан хэрэглэгч аливаа гомдол гаргах эрхгүй.

1.1 Үйлчилгээний үнэ тариф

Үнэ	Хугацаагүй	12 сарын хугацаатай
Суурилуулалтын хураамж	15'000₮	0₮
WiFi төхөөрөмжийн төлбөр	45'000₮	35'000₮
<b>Захиалгат үйлчилгээний төлбөр</b>		
Багц солих		0₮
Гэрээ шилжүүлэх		1'000₮
Үйлчилгээ хадгалах /сар бүр/		1'000₮

1.2 Багцын үнэ тариф

Багц	Хурд	Багцын сарын хураамж	
		/Хугацаагүй/	/12 сарын хугацаатай/*
Хэрэглээний хязгааргүй багц	3Mbps	15'000₮	12'500₮
	5Mbps	18'500₮	16'500₮
	10Mbps	27'500₮	21'500₮
	25Mbps	120'000₮	96'000₮
	50Mbps	210'000₮	190'000₮
Хурдны хязгааргүй багц**	200GB	20'000₮	18'000₮
	400GB	30'000₮	27'000₮
	600GB	40'000₮	36'000₮

\*Хугацаанаас өмнө үйлчилгээ цуцлах тохиолдолд хугацаагүй үйлчилгээний зөрүү болон WiFi төхөөрөмжийн төлбөрийн зөрүүг төлж барагдуулна

\*\* Тухайн багцад дагалдах болон нэмэлт дата багцын хэрэглээнд 100Mbps хүртэлх хурдаар холбогдоно

1.3 Дуудлагаар очиж үзүүлэх үйлчилгээний үнэ тариф

Дуудлагаар үзүүлэх үйлчилгээ	Нэг удаагийн төлбөр*	Тайлбар
- Компьютер болон төхөөрөмжийн тохиргоо хийх - Драйвер таниулах - Өрөө хооронд кабель нэмж татах - Кабель хөндийрөх - Толгой хавчих	8'000₮	1 удаагийн дуудлагаар эдгээр үйлчилгээний аль нэгийг эсвэл бүгдийг нь үзүүлснээс үл хамааран нэг удаагийн төлбөрийг бүрэн төлнө.
- Гэр доторх сүлжээг ахин зохион байгуулах	12'000₮	Хэрэглэгч гэр доторх зохион байгуулалтаа өөрчлөх
- Дахин суурилуулалтын хураамж	12'000₮	Хэрэглэгч нүүх тохиолдолд сүлжээний зохион байгуулалтыг дахин хийх

\*Төлбөрийг бэлнээр төлнө

1.4 Нэмэлт дата багц /Зөвхөн хурдны хязгааргүй багцын дата хэрэглээний эрх дууссан үед ашиглах боломжтой/

Дата эрх	Төлбөр*	Хүсэлт	Тусгай дугаар
50GB	5'000₮	Username 50	132222
100GB	10'000₮	Username 100	

\*Нэмэлт дата эрхийн төлбөр нь өрхийн интернэт үйлчилгээний нэхэмжлэх дээр нэмэгдэж тооцогдоно.

Бүх үнэ тарифт НӨАТ тооцогдсон